

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№22/561

ШУС, НУС

2021

**ӨМӨЗО-НЫ “ОДОН” ТЕЛЕВИЗИЙН МОНГОЛ УЛСАД ГАРЧ БУЙ  
НЭВТРҮҮЛГИЙН АЧ ХОЛБОГДОЛ, ҮР НӨЛӨӨНИЙ АСУУДАЛД**

Алимаа\*

\*МУИС-ийн сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үгс:** “Одон” телевиз, нэвтрүүлгийн шинэчлэлт, үзэгчийн судалгаа, агуулга ба хэлбэр, ур чадвар, уламжлал ба шинэчлэл

**С**этгүүл зүй бол нийгмийн шинжлэх ухааны өвөрмөц салбар бөгөөд ОНМХ-ийн түүх, онол, практик, арга зүйг судалдаг. Дэлхийн сэтгүүл зүйн онолч, түүхчид сэтгүүл зүйн түүхийг судлахдаа нийгэм, улс төр, ардын амьдралд гарсан ахиц дэвшил, чанарын өөрчлөлтүүдтэй холбон тэдгээрийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хэрхэн тусгаж ирснийг онцлон үзэх нь чухал гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг. Телевиз өөрөө нэг бол техник, нөгөө бол агуулга гэсэн хоёрхон зүйлд суурилна.

Монгол Улсын сэтгүүл зүйн нэг онцлог бол онолын тодорхой цэг баримтлалаар биш, харин ном зохиол туурвиж ирсэн үндэстний уламжлал, гадаад улс орны тогтмол хэвлэлийн үлгэр загварт тулгуурлан сонин сэтгүүл гаргаж эхэлсэн байдаг оршино. Телевиз үүсгэн байгуулах бэлтгэл ажил үндсэндээ өнгөрсөн зууны 60-аад оны дунд

үеэс эхэлж, сэтгүүл зүйн уламжлалт хэлбэр болох сонин сэтгүүл үүссэнээс бараг хагас зууны дараа сургалт судалгааны ажил эхэлсэн ажээ.

1997 онд Өвөр Монголын Монгол “Одон” телевиз сансар кабелиар дамжин Улаанбаатарт цацагдан нэвтрүүлснээс хойш Монгол Улсын үзэгч Өвөр Монголын монгол нэвтрүүлэгтэй анх танилцан, цэнхэр дэлгэцээс Өвөр Монгол цаашлан Дундад Улсыг ойлгох боломжийг өргөтгөсөн байна. Ерөнхийлөгч Ши Жиньпиний “Нэг бүс нэг зам”-ын санаачилга нь хил дагасан улс орны дэмжлэгийг авч, онцгойлон Дундад улс болон Монгол Улсын энэ талын харилцаа эрчимтэй хөгжиж, хоёр улсын ХМХ-ийн хамтралцаа өндөр түвшинд хүрэхэд чухал нөлөө үзүүлжээ. Ингээд хоёр орны телевизийн байдал, Өвөр Монголын монгол хэлний хэвлэл мэдээллийн гадаад ухуулгын байдал, Монгол “Одон” телевизийн Монгол Улс дахь нөлөө тусгал, үзэгчдийн хүлээн авч байгаа байдлыг судалж, ажил мэргэжил нэгт хүмүүст судалгааны үр дүнг хүргэхийн хамт үзэгчийн хэрэгцээ

шаардлагыг тодруулахыг зорьсон юм.

*Нэг. Монгол Улсын телевизийн байдал.* Монгол Улсад 1967 оны 9 сарын 27-д зурагт радиог байнгын ашиглалтад хүлээн авснаар монголын теле сэтгүүл зүй эх сууриа тавьсан түүхтэй. Монгол телевиз 9 дүгээр сарын 27-ны орой "Манай анхны зочин" нэвтрүүлгээр уран бүтээлийн түүхийг эхлүүлсэн байна. Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз нь 1967 онд байгуулагдсан Монгол Улсын төрийн өмчийн ууган телевиз нь юм. 1998 онд Монголын Үндэсний Телевиз, 2005 оноос Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз гэж нэрлэх болжээ. 1972 оноос Монгол телевизийн нэвтрүүлэг нийслэл хотын хүрээнээс гарч орон даяар цэнхэр дэлгэц үзэх сайхан үйлсийн эхэл тавигдаж, 1976 оноос өнгөт нэвтрүүлгийг цацаж эхэлжээ. Наяад онд монгол телевизийн материаллаг баазыг бэхжүүлэн нэвтрүүлгийн нутаг дэвсгэрийн хамаарлыг өргөжүүлэн 1981 онд монгол телевиз бүхэлдээ өнгөт телевизэд шилжсэн байна. XX зууны 90-ээд он бол Монголын нийгмийн амьдралын бүхий л хүрээ, түүний дотор сэтгүүл зүйн үйл ажиллагаанд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарсан түүхийн зурвас үе юм. Ерээд оноос монгол телевизийн гадаад харилцаа өргөжиж, 1997 оноос өдөр бүр нэвтрүүлэг явуулах болжээ. МҮОНТ-ийн "Монголын мэдээ" суваг, Спортын суваг, Гадаад хэлний суваг, MNB-ерөнхий суваг, MNB-Sport, MNB World (ангил хэлээр) зэрэг

сувагтай болж, үйл ажиллагаа нь мэдэгдэхүйц өргөжжээ.

2017 оны байдлаар Монгол Улсад 56 радио, 125 телевиз, 89 сонин, 80 сэтгүүл, 96 сүлжээ, нийт 446 хэвлэл мэдээллийн хэрэгсэл тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Телевизийн хувьд кабелийн телевиз, утасгүй IPTV телевиз, хиймэл дагуулын телевиз зэрэг их, бага 125 телевизтэй болжээ. Сүүлийн хэдэн жилд Монгол Улсын телевиз үзэгчийн тоо буурах хандлага ажиглагдаж, 2015 онд хүн амын 77% нь телевиз үзэж байсан бол 2016 онд энэ үзүүлэлт 3%-аар буурчээ. Газар нутгийн хувьд хотын иргэдийн 80% нь телевиз үзэж, насны хувьд 35 - аас дээш насныхан голлон телевиз үздэг бол 34 наснаас доош насныхан нийгмийн мэдээллийн сүлжээ ашиглах нь түгээмэл байна. Монгол Улсын дундаж хүн амын өдөр бүр телевиз үзэх цаг нь 2-3 бол Улаанбаатар хотын иргэдийн телевиз үзэх нь хөдөө нутгаас бага гэсэн судалгааны дүн гарчээ. Хэрэглэгчдийн телевиз үзэх идэвхтэй цаг нь 18:00-00:00-ийн хооронд бол оргил цаг нь 20:00-21:00 буюу түүнээс өмнөх цагт олонх хүмүүс үздэг байна.

**2**006 онд Монгол Улсын Олон Нийтийн Радио Телевизийн тухай хууль батлагдаж Монгол Улс гадаадын хэвлэл мэдээллүүдэд чанга хязгаарлалт тогтоогоогүй боловч тус улсдаа гадаадын программ нэвтрүүлэхэд нэлээд хатуу шаардлага тогтоожээ. 2013 онд Монгол Улсын засгийн газраас баталсан журамд Монгол Улсын Үндэсний

Олон Нийтийн радио телевизийн байгууллага гадаадын программыг тодорхой хязгаарлалттай нэвтрүүлэх талаар заасан байдаг. Харин хувийн телевиз нь гадаадын жуучлууртай хамтран үйл ажиллагаагаа явуулж болно. Үүнд үндэсний нэвтрүүлэг нь заавал 50% хувь байх хэрэгтэй гэдгийг тогтоож өгчээ.

**Х**оёр. *Өвөр Монголын телевизийн байдал.* 1949 оны 10 сарын 1-ний өдөр Бүгд Найрамдах Дундад Ард Улс байгуулагдаж, 1958 оны 5 сарын 1-ний өдөр Дундад Улсын хамгийн анхны суурь телевиз нэвтрүүлгийн хороо - Бээжингийн телевиз нэвтрүүлгийн хороо туршилтын нэвтрүүлэг хийж, 9 сарын 2-ны өдөр сонин мэдээ нэвтрүүлэв. Энэ оны 10 ба 12 сард Шанхайн телевиз хороо ба Харбины телевиз хороо байгуулагдаж, 1961 он гэхэд бүх улсын хэмжээнд нийт 26 телевизийн хороотой болжээ. 1978 оны 5 сард Бээжингийн телевиз хороо гэх нэрийг халж, төвийн телевиз нэвтрүүлгийн хороо (CCTV) гэж нэрлэн 2018 оны 3 сард Уулын төвийн ардын радио нэвтрүүлгийн хороо, Төвийн телевиз нэвтрүүлгийн хороо, Хятадын олон улсын радио нэвтрүүлгийн хороог нэгтгэн Хятадын төвийн радио телевиз (China Media Group) гэж нэрлэх болжээ. Өдгөө жилд 230248 цагийн нэвтрүүлэг, өдөрт 631 цагийн нэвтрүүлгийн сантай болжээ (Гүе Мүечи, 2008).

Өвөр Монголын Өөртөө засах орны сэтгүүл зүйн хувьд цөөн тоот үндэстний хэлээр нэвтрүүлсэн телевиз программ бол Бүгд Найрамдах

Дундад Ард Улсын телевиз үйлсийн чухал нэг бүрэлдэхүүн хэсэг юм. Өвөр Монголын Телевиз хороо 1960 оны 4 сард байгуулагджээ. 1976 оны 10 сард монгол хэлний нэвтрүүлэг эхэлж, 1987 онд тусгай суваг болжээ. 1997 онд дэлхийн 53 улс оронд цацагдах болж, 2009 оноос 24 цагаар нэвтрүүлгээ дамжуулж эхэлсэн юм. 2011 онд “Соёл шинжилгээ” суваг нэмэгдэж, 2016 оны 10 сард Монгол Улсын Улаанбаатар хотод БНХАУ-ын кино орчуулгын халх монгол хэлний нэгдсэн төв байгуулагдаж, 2017 оны 6 сарын 18-ны өдөр “Нахиа” суваг (гарагт 48 цагийн монгол хэлний хүүхдийн нэвтрүүлэгтэй) нээгдсэн байна. Тухайн үеийн Өвөр Монголын телевиз хорооны монгол хэлний нэвтрүүлэг эхэлсний дараа Өвөр Монголын аймаг хотын телевиз хороо Шинжаан, Хөх нуур зэрэг монголчууд төвлөрөн суудаг газарт өөр өөрийнхөө телевизийг эрхлэх нөхцөл бололцоогоо үндэслэн нийгэм хүмүүжил, соёл урлаг, үйлчилгээний чанартай хөтөлбөрдийг тогтмол болон тогтмол бус хугацаатайгаар нэвтрүүлж эхэлжээ. Энэ бол Монгол телевизийн үйлсэд хайртай олон хүний хамтын чармайлын үр дүн байсан бөгөөд явцдаа өнөөдрийн Монгол “Одон” телевиз болон төлөвшжээ.

Монгол “Одон” телевиз нь Ази номхон далайн орны 53 улс оронд цацагдаж, сувгийн программ нь ӨМӨЗО-ы бүх аймаг, хот, хошуу, шянь ба Шинжаан, Хөх мөрөн, Гансу, Ляонин, Грин, Хар мөрөн, Хээбэй зэрэг монгол үндэстэн төвлөрөн суудаг газар орон болон Монгол Улс,

ОХУ-ын Буриад, Тува, Халимаг гурван Бүгд Найрамдах Улс, Австрали зэрэг улс оронд 24 цагийн нэвтрүүлэг цацдаг.

ӨМӨЗО-ы монгол хэлний хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь үндэстний оронд аж ахуй, соёл, ардын амьдралд үйлчлэх мөртөө зэргэлдээ муж орон, хөрш улсад гадаад ухуулгыг сурталчлах гүүр болдог онцлогтой. ӨМӨЗО-ы монгол хэлний уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл хагас зуу илүү жилийн хөгжилтийг дамжин Өвөр Монголын Өдрийн Сонины Хорооны монгол хэвлэл ба 12 аймаг хотын монгол сонин жич хам жуучлуур, Өвөр Монголын Радио Телевиз хорооны монгол хэлний нэвтрүүлэг ба 12 аймаг хот, хошуу, шяний Радио телевиз хорооны хам жуучлуур, “Өнөр цэцэг” зэрэг хэдэн арван сэтгүүл ба Ардын Хэвлэлийн Хороо мэт долоон хэвлэлийн хороо үйл ажиллагаа явуулж байна. Өвөр Монголын Өдрийн Сонины Хорооны хувьд гадаад ухуулгын “Солонго” сэтгүүлтэй бөгөөд тус сэтгүүл нь 2010 оны 10 сарын 20-оос монгол (монгол бичиг, кирилл бичиг), хятад, орос гурван хэл дөрвөн үсгээр үйл ажиллагаагаа явуулж, Монгол Улсын 21 аймагт тархдаг. Өвөр Монголын Радио Телевиз Хорооны “Талын дуу хоолой” радио нь Улсын сонин мэдээ, хэвлэл, радио телевизийн ерөнхий товчооноос зөвшөөрсөн Өвөр Монголын анхдагч Монгол Улсын сонсогчдод зориулсан радио нэвтрүүлэг юм. 2013 оны 3 сарын 1-ээс Монгол Улсад монгол хэлний халх аман аялгуугаар сонин мэдээ,

нэвтрүүлгийн хэлбэрээр Дундад Улсын дуу хоолойг дамжуулж иржээ. Өдгөө Монгол Улсад FM 107.5 долгионоор өдөрт 8 цагийн нэвтрүүлэг явуулж байна.

**Г**урав. *Монгол дахь Монгол “Одон” телевизийн үзэгчдийн байдал.* БНХАУ 1949 оны 10 сарын 1-ний өдөр байгуулагдан, Май Зэдүн дэлхий дахинд Бүгд Найрамдах Дундад Ард Улсыг тунхагласан байна. 1949 оны 10 сарын 6-нд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ерөнхий сайд, Гадаад явдлын яамны сайд Х.Чойбалсан харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа БНХАУ-ын Ардын засгийн ордны Гадаад явдлын яамны сайд Жөү Эньлайд ил-гээж, 16-ны өдөр харилцан бие биеэ хүндэтгэн хүлээн зөвшөөрч, элчин сайдын яам байгуулагдаж, 1994 онд "Дундад Монголын нөхөрсөг харилцааны хамтын ажиллагааны гэрээ"-д гарын үсэг зурснаараа нөхөрсөг хөршийн улс төр, аж ахуй, эдийн засаг, соёл урлагийн зам нээгдэж, тэр цагаас хойш хоёр орны ард түмэнд ач буянаа хүртээж хуучны цагийн “Цайны зам” шинэ эрчмээр амьсгалж эхэлсэн билээ. Дундад Монгол хоёр улс 1951 оноос соёлын харилцаа тогтоож, 1994 онд "Дундад Монголын соёлын солилцоод хамтран ажиллах гэрээ"-нд гарын үсэг зуржээ. 2019 онд Дундад Монголын гадаад харилцаа хамтын ажиллагааны 70 жил, "Дундад Монгол хоёр улсын нөхөрсгөөр хамтран ажиллах харилцааны гэрээ"-г шинэчлэн тогтоосны 25 жилийн ой болсон юм. Сүүлийн жилүүдэд Дундад Монголын хамтын ажиллагаа өргөжихийн

хэрээр хоёр улсын соёл урлагийн хамтын ажиллагаа, тэр дундаа радио телевиз, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагаа улам бэхжиж, хоёр улсын нөхөрсөг харьцааг бататгахад идэвхтэй нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын үзэгчдийн Монгол “Одон” телевизийг үзэх дуртай нэвтрүүлгийн төрлийг 2017

оны судалгаанаас үзэхэд мэдээ, уран сайхны кино, цэнгээнт нэвтрүүлэг, дуу хөгжим, ярилцлага, спорт бөгөөд тэдний харьцаа нь тус тус 61, 52, 23,11,10, 9-д хүрч байна. “Одон” телевизийн “Одод түгэх цаг”, “Урсгал” зэрэг нэвтрүүлгийг Global, Ulzii channel, Asia Mongolia телевиз сувгуудаар жилд 1599 удаа нэвтрүүлсэн байна.

Хүснэгт 1. Нарс, Гүй Ин. Монгол Улсын телевиз жуучлуурын тухай судалгаанаас. Эх сурвалж: "Үндэстний сонин мэдээ, хэвлэл, радио кино телевиз" сэтгүүл. 2018. №6, х.7.

№	Төрөл	Төгсөх өдөр	Төгсөх цаг	Төгсөх минут
1	Орчин цаг	2017/4/23	17:52:01	3.4
2	Хэвлэл (2459)	2017/1/9	13:16:13	2.3
3	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/3/26	15:12:14	2.14
4	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/4/4	20:44:33	1.7
5	Орчин цаг : 70 минут	2017/8/4	02:28:01	1.6
	Хэвлэл (1124)	2017/1/13	18:29:05	1.6
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/1/13	18:44:38	1.6
6	Орчин цаг (175)	2017/8/18	18:21:39	1.4
	Орчин цаг (449)	2017/1/14	12:53:39	1.4
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/5/14	23:45:23	1.4
7	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/8/9	20:03:48	1.3
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/3/29	22:40:21	1.3
8	Орчин цаг (548)	2017/9/10	12:25:44	1.2
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/1/13	17:52:01	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/1/28	19:54:41	
9	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/2/6	24:35:19	1.1
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/1/27	19:51:11	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/5/11	10:54:37	
	Орчин цаг : Шинэ мэдээ (131)	2017/9/27	17:20:20	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/9/27	18:49:49	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/9/27	18:00:19	
10	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/9/27	19:00:16	1
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/1/12	13:39:06	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/7/29	18:01:12	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/3/26	20:00:00	
	Орчин цаг : Шинэ мэдээ (50)	2017/2/22	13:52:36	
	Орчин цаг : Шинэ мэдээ (19)	2017/2/22	14:52:36	
	Орчин цаг : Шинэ мэдээ	2017/2/22	15:07:38	
Орчин цаг : Шинэ мэдээ (219)	2017/5/7	18:43:53		
Орчин цаг : Шинэ мэдээ (1188.1189)	2017/9/27	16:50:18		

Хүснэгт 1. Нарс, Гүй Ин. Монгол Улсын телевиз жуучлуурын тухай судалгаанаас. Эх сурвалж: "Үндэстний сонин мэдээ, хэвлэл, радио кино телевиз" сэтгүүл. 2018. №6, х.7.

Maxia Media компанийн 2021 оны эхний улирлын (3 сарын 3 долоо хоног) жишээнээс үзэхэд “Одон” телевизийн ерөнхий хүлээн авалтын норм 0.045, 0.026, 0.024 байж, Монгол Улсад гарч буй 64 телевиз сувгийг харьцуулсны эцэст 37,47,47 дугаарт орж, хамгийн их хүлээн авалт нь 1.453, 2.282, 3.044 байжээ. Тус гурван гарагт мэдээний төрлөөс үдийн сонин мэдээ 0.203,

өглөөний мэдээ 1.197, үдшийн мэдээ 0.247, нэвтрүүлгээс "Соёл эрдэнэ" 1.294, орчуулгын баримтат кино (хоёр гараг) 0.98 ба 0.353, сурталчилгааны киноноос "Нийдэм хэрэглэх үг хэл үсэг бичлэг" нь 1.453, "Өвөр Монголын тал нутгийн кино" 1.282, "Арвилан гамнах" бримтат кино 3.004, теле жүжгээс "Аав хүү хоёул" хошин жүжиг 1.394, "Нэг ч

дутагч болохгүй" теле жүжиг 0.457 гэсэн дарааллаар оржээ.

Гурван жилийн өмнөх адил сарын судалгаанаас үзэхэд Төвийн Телевиз Хорооны сонин мэдээний үзэгчийн хүлээн авалтын норм 1.3 -д, нэвтрүүлгээс "Тамирын чуулган"-ы үзэгчийн хүлээн авалтын норм 1-д, телевиз жүжиг "Барууныг зорьсон үлгэр"-ийн үзэгчийн хүлээн авалтын норм 2.14-д хүрчээ. Монгол "Одон" телевизийг Монгол Улсын үзэгчид нэвтрүүлэг ба сонин мэдээ, Хятадын сонгодог зохиолын жүжгийн хувьд харьцангуй тогтмол, теле жүжгийг сонирхох нь бага зэрэг буурах, сурталчилгаа рекламьг сонирхох нь нэлээд нэмэгджээ.

**Ү**үнд сэтгүүлчийн ур чадвар ихээхэн шаардагдана. Сэтгүүлчийн ур чадвар гэдэг бол зөвхөн хэлбэрийн ур чадвар биш, харин хэлбэрийг зөв гаргах ур чадвар юм. Энэ бол агуулга хэлбэрийн нэгдлийг өндөр түвшинд хангах гэсэн үг юм. Сэтгүүлчийн аливаа нийтлэл нь үүрэг – сэдэв - агуулга - хэлбэр гэсэн үндсэн ойлголтуудын гинжин хэлхээнээс тогтдог (М.Зулькафиль, 2016). Телевизийн сэтгүүлчийн чадварыг авч үзэхэд түүний өөрийнх нь уран сайхны онцлог, тэнд ажиллаж байгаа сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадвар гэсэн хоорондоо уялдаатай боловч харьцангуй бие даасан хоёр ухагдахуунд анхаарлаа хандуулах хэрэгтэй болдог (Л.Норовсүрэн, 2010). Иймээс теле сэтгүүл зүйн өвөрмөц нөлөөлөх хүчин чадлаас гадна сэтгүүлчдийн өөрсдийнх нь мэдлэг чадварын түвшнээс ихээхэн шалтгаалж, уран

бүтээлийн чанар чансаа, үзэгчдийн хүлээн авч үзэх байдал нөлөөлнө.

*Дүгнэлт.* Телевиз үзэгчийн тухай ойлголт бол теле сэтгүүл зүйн чухал асуудлын нэг мөн. Телевизийн нэвтрүүлэг зөвхөн үзэгчдэд зориулсан учраас тэдний хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээ, боловсрол, нийгмийн байдал зэргийг нарийвчлан судлах нь үр нөлөөний чухал хүчин зүйл болдог. Иймийн тулд Өвөр Монголын Монгол "Одон" телевиз Монгол Улсад нэвтрүүлгээ хүргэхийн тулд үзэгчээ сайн судалж, үзэгчийн тухай мэдлэгтэй байх нь зүйтэй. Үзэгчийг нас, хүйс, газар зүйн байршил, мэдлэг боловсрол зэрэг таван төрөлд хуваах боловч хамгийн гол нь сонирхлоор нь ангилах нь чухал юм. Тиймээс үзэгчдээ судалж тэдний дуртай, хүсэн хүлээдэг нэвтрүүлгийг бэлтгэж өгөх нь тэргүүн зэргийн шаардлага мөн. Телевизийн үзэгчдийг судлах бага хурал, уулзалт, анкетын арга, сурвалжилгын арга, баримт бичиг судлах зэрэг цөөнгүй арга бий. Үүнд хоёр орны телевиз уран бүтээлчийн чуулга уулзалт, "Солонго", "Инээдтэй үдэш" зэрэг уран сайхны цэнгээнт нэвтрүүлгийг эс тооцвол бусад судалгаа хараахан харагдахгүй байна. Үзэгчийг судлах нь үр дүнд хүрэхийн эхлэл мөн. Энэ үйл явц нөлөө-үр дүн, нөлөөлөл -үр ашиг гэсэн дарааллаар явагддаг. Түүний үр ашиг нь оюун санаа ба практик гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Чухам оюун санаанд практикт ач тус хүргэхийн тулд нэн илүү мэдлэг, мэдээлэлтэй, өөрөөр хэлбэл ажил амьдралд шууд ач тусаа үзүүлэх

нэвтрүүлэг бэлтгэн хүргэх шаардлага телевизийн уран бүтээлчдэд тулгарч байна. Ялангуяа хэвлэл мэдээллийн уламжлал шинэчлэлийг хослуулсан сонин мөртөө содон нэвтрүүлэг хүргэх нь зүйтэй гэж үзэж байна.

#### Эшлэл

1. Гүе Мүечи. Манай улсын телевиз нэвтрүүлгийн гадаад дахь хүлээн авалтын талаар мөчид өгүүлэх нь //“Сонин мэдээний танин мэдэхүй”, 2008, №2 (Өөрийн орчуулга). □ 郭墨池 《浅论扩大我国对外电视媒体影响力的对策 —CCTV4 为例》【J】 新闻知识 2008.2.
2. Зулькафиль М. 2016.Сэтгүүл зүйн талбар толь. Ху.217.
3. Норовсүрэн Л. 2010. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Ху. 304.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Гүе Мүечи. Манай улсын телевиз нэвтрүүлгийн гадаад дахь хүлээн авалтын талаар мөчид өгүүлэх нь //“Сонин мэдээний танин мэдэхүй”, 2008, №2 (Өөрийн орчуулга). □ 郭墨池 《浅论扩大我国对外电视媒体影响力的对策 —CCTV4 为例》【J】 新闻知识 2008.2.
2. Зулькафиль М. 2016.Сэтгүүл зүйн талбар толь. Өвөр Монголын их сургуулийн хэвлэлийн хороо. Хөххот.
3. Нарс, Гүй Ин. 2018.6.Монгол улсын телевиз жуучлуурын тухай судалгаа //“Үндэстний сонин мэдээ хэвлэл радио кино телевиз” сэтгүүл. Хөх хот.
4. Норовсүрэн Л. 2010. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. Өвөр

Монголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот.

5. Бүгд Найрамдах Дундад Ард Улс, Монгол Улсын хоорондох дипломат харилцаа тогтоосон жаран жил. 2009. Дэлхийн хэвлэл мэдээллийн газар. УБ.
6. Монгол “Одон” Телевизийн Монгол Улс дахь хүлээн авах норм. 2021. Дотоод материал. Хөх хот.

#### Summary

It is important to study the audience and prepare the programs they like, expect and need. Audience research is the beginning of producing good TV programs. When making TV programs, TV workers not only need to enrich the audience's spiritual world and take into account the practical significance of the program, but also urgently need to provide the audience with programs with more abundant knowledge and information, that is, programs directly beneficial to work and life. In particular, it is important to provide audiences with a unique program that combines traditional media with technological innovation. To be a good reporter, there are three requirements: talent, knowledge and hard work. Therefore, As an important external publicity media in Inner Mongolia Autonomous Region of China, Inner Mongolia SATELLITE TV should, based on theory and practice, speed up technological progress, innovate content and communication methods, and take the road of development. In the context of deepening cooperation between China and Mongolia, it is important to share experience with talented TV producers, learn from each other, conduct joint research, and guide the exploration of the way to combine new media and traditional media.